

НЭГ УГСАА - НАЙРСАГ ХАРИЛЦАА

KÖZÖS MŰLT

*Унгар-Монголын Дипломат харилцааны
70 жилийн ойд зориулан бүтээв.*

*A magyar-mongol diplomáciai
kapcsolatok 70. évfordulójára*



Улаанбаатар хот
2020 он

Ulánbátor, 2020



НЭГ УТСАА - НАЙРСАГ ХАРИЛЦАА KÖZÖS MŰLT

УНГАР-МОНГОЛЫН ХООРОНД ДИПЛОМАТ ХАРИЛЦАА ТОГТООСНЫ 70 ЖИЛИЙН
ОЙД ЗОРИУЛСАН ГЭРЭЛ ЗУРГИЙН ТОВХИМОЛ

A MAGYAR-MONGOL DIPLOMÁCIAI KAPCSOLATOK FELVÉTELÉNEK 70.
ÉVFORDULÓJA ALKALMÁBÓL KÉSZÜLT FÉNYKÉPALBUM

Эрхлэн гаргасан:

- Унгар Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Др.Обрущанский Борбала Анна
- Монгол Улсын Архивын Ерөнхий газар

Хянан тохиолдуулсан:

- Монгол судлаач Телеки Кристина
- Элчин сайдын Нарийн бичгийн дарга Г.Хишигбадам

Гэрэл зургийг:

- Монгол Улсын Архивын Ерөнхий газар
- www.montsame.mn мэдээллийн агентлаг
- Унгарын МТИ мэдээллийн агентлаг
- Унгарын Элчин Сайдын Яам
- Унгарын антропологич, кино найруулагч Фүреди Золтан

Szerkesztő:

- Dr.Obrusánszky Borbála Anna, Magyarország Ulánbátori rendkívüli és meghatalmazott nagykövete
- Mongol Állami Archívumi Főhivatal

Szakmai lektor:

- Teleki Krisztina, mongolista
- G. Khishigbadam, Magyarország Ulánbátori Nagykövetének titkára

Gyűjtemények:

- Mongol Állami Archívumi Főhivatal
- Montsame Állami Híregyhely, www.montsame.mn
- Magyar Távirati Iroda (MTI) Archívum
- Magyarország Ulánbátori Nagykövetsége
- Füredi Zoltán, antropológus, filmrendező

Энэхүү товхимол номыг санаачлан, эрхлэн гаргасан УНГАРЫН ЭЛЧИН САЙДЫН ЯАМ-ны зөвшөөрөлгүйгээр олшруулах, цахим хэлбэрт оруулах, хэвлэхийг хориглоно.

© Jelen kiadvány sokszorosítási, digitalizálási, nyomtatási jogát Magyarország Ulánbátori Nagykövetsége fenntartja.

УНГАРЫН ЭЛЧИН САЙДЫН ЯАМ

www.mission.uln@mfa.gov.hu

Харилцах утас: +976 77005600, +976 99072224

ISBN 978-9919-9379-0-4

МЭНДЧИЛГЭЭ

Монгол Улс, Унгар Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ой энэ онд тохиож байна. Өнө эртний хэлхээ холбоотой манай хоёр улсын харилцаа хэдэн зууныг дамжин өртөөлсөн баялаг түүхтэй билээ.

Монгол, Унгарын харилцаа, хамтын ажиллагаа он цагийн шалгуурыг даван туулж, өнгөрсөн 70 жилийн хугацаанд бүхий л салбарт өргөжин хөгжсөнийг онцлон тэмдэглэхэд таатай байна. Манай хоёр улсын эдийн засгийн хамтын ажиллагаа 1960-аад оноос эхлэн эрчимтэй хөгжиж, Унгарын ард түмний тусламжаар олон тооны үйлдвэр байгуулагдсан нь манай улсын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсныг монголын ард түмэн ямагт талархан дурсдаг.

Монгол, Унгарын ард түмний хоорондын хэлхээ холбоо алс холыг үл ажран тасралтгүй бэхжиж, харилцааны тэргүүлэх чиглэлийн нэг

болох боловсролын салбарын хамтын ажиллагаагаар дамжин улам өргөжиж буйг бахархан тэмдэглэж байна.

Манай хоёр улсын уламжлалт найрсаг харилцааг улам өргөжүүлэн бэхжүүлэх, эдийн засгийн харилцааг шинэ шатанд гаргахын төлөө унгар анд нөхөдтэйгээ хамтран ажиллаж буйн үр шимээр ирж буй он жилүүдэд хоёр орны ард түмэнд өгөөжтэй, харилцан ашигтай хамтын ажиллагаа өргөжин хөгжинө гэдэгт миний бие итгэл төгс байна.

Монгол, Унгарын харилцаа, хамтын ажиллагааны түүхийн гол үйл явдал, сэтгэлд хоногшсон дүр төрхийг харуулсан ховор нандин гэрэл зургуудыг эмхтгэн дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ойд зориулан олон нийтийн хүртээл болгож буй Унгар Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яаманд гүн талархал илэрхийлье.



MINISZTERI KÖSZÖNTŐ

Ebben az évben ünnepeljük Mongólia és Magyarország között létrejött diplomáciai kapcsolat létrejöttének 70. évfordulóját. Országaink között sokrétű, gazdag, évszázados történelmi kapcsolat mutatható ki.

Örömtelinek tartom, hogy a mongol-magyar kapcsolat kiállta az idő próbáját és az eltelt 70 évben számos együttműködési területen bővült. A mongol nép mindig is nagyra értékelte az országaink közötti gazdasági együttműködés gyors fejlődését az 1960-as évektől, amelynek keretében számos üzem jött létre a magyarok segítségével, mely értékes hozzájárulást jelentett hazánk fejlődéséhez.

Bátran kijelenthetjük, hogy a mongol és a magyar nép közötti kapcsolatokat nem zavarta meg a nagy távolság, sőt azok hosszú időn át folyamatosan erősödtek; ezek közül kiemelkedik az oktatás

területén folytatott együttműködés, amely relációnk egyik prioritása.

Bízom abban, hogy az elkövetkező években országaink továbbra is profitálnak a kölcsönösen előnyös együttműködésből, s magyar barátainkkal együtt dolgozhatunk hagyományos baráti kapcsolataink további bővítésén és megerősítésén, valamint a gazdasági kapcsolatok új szintre emelésén.

Szeretném kifejezni szívből jövő hálámat Magyarország Ulánbátori Magyar Nagykövetségének a ritka fényképsorozat összeállításáért, amelyeket a diplomáciai kapcsolatok felvételének 70. évfordulójának tiszteletére gyűjtöttek össze, és amelyek a mongol-magyar kapcsolatok és együttműködés történetének legfontosabb és legemlékezetesebb eseményeit örökítik meg.

NYAMTSEREN ENKHTAIVAN, KÜLÜGYMINISZTER,
A MONGOL KORMÁNY TAGJA

МЭНДЧИЛГЭЭ

2020 онд Унгар, Монголын хооронд Дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ой тохиож байна. Түүхт ойн хүрээнд Унгар Улсын Элчин сайдын яамнаас хоёр орны түүхэн найрсаг, хамтын ажиллагааны түүхийг өгүүлсэн Фото зургийн үзэсгэлэнг Нацагдоржийн нэрэмжит Улаанбаатар хотын төв номын сангийн вэбсайт дээр онлайн хэлбэрээр зохион байгуулж байна. Мөн Та бүхэнд энэхүү Фото зургийн товхимолыг өргөн барьж байна.

Унгар, Монгол хоёр орны түүхэн харилцаат энэ жилүүдэд улс төрийн дээд түвшний айлчлалууд өрнөж, бүхий л салбарын харилцаа хөгжиж, тэр дундаа хөдөө аж ахуй, боловсролын салбарын хамтын ажиллагаа илүү өргөжин тэлж байгаад баяртай байна. Бидэнд хамтдаа бүтээж, хамтдаа хөгжсөн сайхан түүх их бий. Тухайлбал, Унгарын усны мэргэжилтнүүд Монголын говь цөлд олон зуун худаг өрөмдсөн бөгөөд нутгийн малчид одоог хүртэл Унгарын худаг гэж нэрлэдэг. Судлаачид, уран бүтээлчид, зохиолчид хоорондоо холбоо тогтоож хамтарч, ном гаргаж, кино хийсэн байдаг. Монголын эртний түүх, соёлын дурсгалт газруудыг судлах хамтарсан экспедицүүдийг эхлүүлсэн.

Унгар, Монголын Дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ойн

хүрээнд олон чухал ажлуудыг хийхээр төлөвлөж байсан боловч дэлхий нийтийг хамарсан цар тахлын улмаас ажлуудын маань ихэнх нь цахимаар эсвэл хэвлэмэл хэлбэрээр үргэлжилж байна. Гэвч ирэх жил хоёр орны найрсаг харилцаа, хамтын ажиллагаа улам өргөжин тэлсэн жил байна гэдэгт итгэж байна.

Унгар Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд миний бие өнө эртний түүхт Монгол орны түүх, нүүдлийн соёл иргэншил, зан заншлыг шимтэн судалдаг Монголч эрдэмтэн бөгөөд өдгөө Унгар Улсыг төлөөлөн суухдаа хоёр орны харилцаа, хамтын ажиллагааг улам өргөжүүлэхийг маш их хичээж байна. Унгарын мэргэжилтнүүд Монгол оронд дахин ирж ажиллаж, харилцан туршлага солилцож, хамтдаа хөгжих бүрэн боломж байна. Ийнхүү харилцаагаа өргөжүүлэхийн тулд Унгарын соёлын чухал суурь болж чадах Унгар хэлний тэнхимийг Улаанбаатарт байгуулах хэрэгтэй хэмээн төлөвлөж байна.

Төгсгөлд нь энэхүү гэрэл зургийн товхимолыг бэлтгэхэд маш их туслалцаа үзүүлсэн Телеки Кристина мөн профессор Бирталан Агнеш, Коня Альберт, Фүреди Золтан нарт талархал илэрхийлье.



TISZTELT OLVASÓINK!

2020-ban ünnepeltük a magyar-mongol diplomáciai kapcsolatok felvételének 70. évfordulóját. Ebből az alkalmából összegyűjtöttünk 70 képet, és online kiállítás formájában közzétettük az ulánbátori, Fővárosi D. Natsagdorj Könyvtár honlapján. Ezek a képek rövid ízelítőt adnak a két ország közti, rendkívül sokrétű kapcsolatról.

Az elmúlt évtizedekben a magas szintű politikai látogatások mellett gyárak épültek, amelyek épületei sok helyen még ma is állnak. Magyar vízügyi szakemberek több száz kutat fúrtak a Góbi-sivatagban, amelyet a helyi pásztorok még mindig magyar kutatknak emlegetnek. Kutatók, művészek, írók vették fel egymással a kapcsolatot, könyvek jelentek meg, filmek készültek. Közös expedíciók indultak Mongólia ősi emlékeinek feltárására. Elmondhatjuk, hogy pezsgő szellemi élet jellemezte és jellemzi a két ország közti kapcsolatot.

A 70 éves évfordulóhoz méltó megemlékezésre, nagyszabású

rendezvényre a Covid-19 járvány miatt nem kerülhetett sor, azonban a jövő évben ezeket pótoljuk, és új lendülettel kezdjük meg a következő éveket, évtizedeket.

Magam eddig kutatóként dolgoztam mongol kollégáimmal, most nagykövetségként próbálom a kapcsolatokat bővíteni és képviselni hazánkat, Magyarországot ebben a csodálatos országban, Mongóliában. Most megvan a lehetőség, hogy közös történelmi gyökerekre alapozva kiszélesíthetjük az együttműködési területeket, és újra magyar szakemberek dolgozzanak ebben az Európától távoli országban. Célunk, hogy magyar nyelvi tanszék alakuljon Ulánbátorban, amely a magyar kultúra fontos bázisa lehetne.

Végezetül külön köszönetet szeretnék mondani Teleki Krisztinának, aki sok segítséget nyújtott a fotóalbum előkészítésében, Birtalan Ágnes professzornak, Kónya Albertnek és Füredi Zoltánnak, akik kiváló képeket biztosítottak a jelen kiadványhoz.

DR. OBRUSÁNSZKY BORBÁLA ANNA
RENDKÍVÜLI ÉS MEGHATALMAZOTT NAGYKÖVET



УНГАР-МОНГОЛЫН ДИПЛОМАТ ХАРИЛЦАА ТҮҮХИЙН ХУУДАСНАА



Унгар, Монгол хоёр улс 1950 оны 4 дүгээр сарын 28-нд Дипломат харилцаа тогтоосон бөгөөд 1957 онд Будапешт, Улаанбаатар хотуудад дипломат төлөөлөгчийн газруудаа нээсэн билээ. Албан ёсны харилцаа ийнхүү хожуу тогтсон хэдий ч хоёр улсын ард түмэн хэдэн зуун жилийн өмнө буюу Дундад зууны үед холбоо харилцаатай байсан тухай баримтууд байдаг.

Тухайлбал, Унгарын Доминикийн лам Юулианус Зүүн Европ руу аян дайн хийж байсан монголчуудын талаар тэмдэглэн үлдээсэн нь бий. Тэрээр 1237 онд Монголын Бат хаанаас Унгарын Бела IV хаанд бичсэн захидлыг авчирч өгч байжээ. Түүнчлэн 1241-1242 оны Европ дахь монголчуудын байлдан дагуулалтын дараа Унгарын хаант улс Алтан Ордтой зэрэгцэн оршиж байсан ба тэд худалдааны болон дипломат харилцаа тогтоосон байв. Тухайн үед Унгарын аялагч, эрдэмтэн судлаачид мөн Христийн шашны номлогчид Алтан Ордын улсын газар нутагт амьдардаг байжээ.

Унгарууд XVIII зуунд өвөг дээдсийнхээ суурьшиж байсан газар нутгийг илрүүлэн тогтоохыг эрмэлзэж, дорно дахин тийш судалгаа шижилгээний зорилго бүхий аялалуудыг хэд хэдэн удаа зохион байгуулж байсан талаар цөөнгүй

ном зохиол байдаг бөгөөд тэдний судалгааны зорилгыг язгууртны захидал гэрчилдэг. 1878 онд Сэцэни Бела ноён Өвөр Монголын нутаг болон эртний Торгоны замаар судалгаа хийхээр явахынхаа өмнө Хятадын Засаг даргад бичсэн захидалдаа: “Надад ямар нэгэн улс төр, шашин дэлгэрүүлэх болон арилжаа наймааны зорилго байхгүй, зөвхөн шинжлэх ухаан, түүхийн судалгаа хийх санаа байна. Миний хамгийн их хүсч буй зүйл бол бид өвөг дээдсийнхээ амьдарч байсан газар нутагтай танилцах, IX зуунд Унгар улс үүсгэн байгуулагдаж, өнөөг хүртэл оршин тогтнож байгаагийн төлөө тэдний булшинд хүндэтгэл үзүүлж, залбирах явдал юм” гэж бичсэн нь Унгарууд болон дорно дахины ард түмэн түүхэн харилцаатай байсан гэдгийн нэгэн нотолгоо юм.

Унгарууд эртний өвөг дээдсээ “хайж байхдаа” 1757-1765 оны хооронд франц хэл дээр хэвлэгдсэн Йозеф де Гуйнэсийн “Хүннү, монгол, турк, татаруудын түүх” хэмээх номноос Хүннүчүүд Азийн төв болон Монгол улсад амьдарч байсныг олж мэджээ. Ингээд XIX зууны эхний хагаст Унгарын Дорно дахин судлаач, эрдэмтэн Көөрөши Чома Шаандор Өвөр Монголын Шар мөрний сав газарт суурьшин амьдарч байсан Хүннү удмынхантай уулзахаар төлөвлөж



байсан боловч харамсалтай нь очиж чадаагүй юм. Түүний дараа Унгарын Шинжлэх Ухааны Академийн нэрт эрдэмтэн Фогараши Яанош “Мажар хэлний толь бичиг”-ийг эмхэтгэхдээ унгар үгийг монгол үгтэй харьцуулан судалж, үр дүнд нь хүннү хэлний шинж чанарыг гаргаж ирэх зорилт тавьсан. Ингээд Фогараши Яанош энэхүү судалгааны ажилд хэнийг томилох талаар Унгарын нэрт турк судлаач Вамбери Арминтай санал солилцоход тэрээр хэлний авьяастай, залуу судлаач Балинт Габорыг санал болгожээ.

Ингээд Унгарын Шинжлэх Ухааны Академийн шугамаар Балинт Габорыг Каспийн тэнгисийн эрэг дээрх Халимаг руу явуулсан. Балинт баруун монгол аялга болон татар, черемез, орос хэлийг маш хурдан сурчээ. Балинт Габор Өргөө рүү явах асаа өмнө буюу 1872 онд дорнын монгол аялгууг сурах хүсэлтэй байгаа тухай өргөдөл бичиж Академид хүргүүлэв. Академиас зөвшөөрөл аваад Оросын хаанаас дэмжлэг хүсэхээр Оросын нийслэлд очсон. Тэнд хааны зураач байсан Зичи Михай гэдэг унгар хүний тусламжаар орос хаан зарлиг гаргаж, Балинт Габорын Монгол руу явах замын зардлыг шийдэж өгсөн. Ингээд 1873 оны 2 дугаар сард Оросоос гарч, хоёр сарын дараа Өргөөд ирэв. Тухайн үеийн Оросын хааны тушаалаар Балинт Габор Өргөө дэх Оросын консулын газарт амьдарчээ. Тэрээр 155 хоног Монголд байх хугацаандаа олон арван ардын аман зохиол, бичвэрүүдийг цуглуулсан байдаг.

1875 онд Унгарын язгууртан Зичи Йозеф, Зичи Агошт хэмээх ах дүү хоёр Бээжингээс гарч, говь цөлийг гатлан Монголд ирээд хэсэг хугацаанд байсны дараа Орос руу явсан. Тэд дараа нь

“Говийн тухай тэмдэглэл” хэмээх зохиол бичихдээ Балинт Габорын тэмдэглэлээс эш татаж оруулжээ.

Үүний зэрэгцээ 1872 онд эхлээд Будапештийн Их Сургуульд дараа нь Коложвар хотын Ференц Йозефын их сургуульд Алтай судлалын тэнхимийг байгуулагджээ.

1898 онд Монголын нийслэл Өргөө хотод дахин нэгэн унгар эрдэмтэн ирсэн нь Зичи Енө байв. Тэр нэг долоо хоногийн турш Өргөөтэй танилцан судалгаа хийж, түүхийг өгүүлсэн олон гэрэл зураг авсан байдаг. Түүнтэй хамт Унгарын угсаатны зүйч, археологич, амьтны судлаач нар ирсэн бөгөөд тэд ч маш сонирхолтой баримтуудыг цуглуулсан байна. Зичи Енө 1898 оны 9 дүгээр сарын 11 хүртэл Өргөө хотод байж байгаад дараа нь Бээжин рүү аялав. Зичи Енөгийн багийнхан Монголын болон нийслэл Өргөөгийн тухай маш их сонирхолтой материал цуглуулсан боловч түүнийг Монгол судлалд бараг хэрэглээгүй юм.

Өдгөө Унгар, Монголчуудын аль аль нь өөрсдийнхөө өвөг дээдэс гэж үздэг Хүннүгийн судалгааг хоёр орны харилцааны чухал хэсэг болгон ярих шаардлагатай юм. Монголын археологичдоос Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, Улаанбаатар Их сургуулийн багш, археологич Диймаажавын Эрдэнэбаатар 2012-2016 онд Ази, Европын Хүннүчүүдийн харьцуулсан судалгаа хийсэн. Тэрбээр Унгарт болон Румын улсын Унгарууд суурьшсан бүс нутгуудаар гурван удаа аялж, археологи, угсаатны зүйн дурсгалт газруудад судалгаа хийсэн. Энэ тухай Унгар, Монголын эрдэм шинжилгээний сэтгүүлүүдэд бичсэн нь бий. Түүнчлэн түүхч, монголч эрдэмтэн Др. Обрущанский Борбала Аннагийн

Хүннүчүүдийн түүхийг судалсан нэг сэдэвт бүтээл Монгол, Унгар хоёр улсад хэвлэгдсэн байна.

Дэлхийн I дайны үеэр Оросын цэрэгт олзлогдон Сибирийн хорих лагериудад хоригдож байгаад суллагдсан Унгарууд төрөлх нутаг руугаа буцахыг хүсч байсан ба зарим нь баруун тийш Унгар луу харин зарим нь зүүн тийш Монголын нутаг руу явсан байдаг. Тухайлбал, хожим Унгарын Ерөнхий сайд болсон Надь Имрэ Сэлэнгийн буриадуудтай, намын Ерөнхий нарийн бичгийн дарга байсан Ракоши Матиаш Чита хотод буриадуудын дунд гурван жил амьдарч байжээ. Тэгвэл тэр үед Монголын Засгийн газар байж байгаад дараа нь анхны үндэсний театр болсон “Бөмбөгөр ногоон”-ыг байгуулалцаж, анхны халаалтын төвийг зохион бүтээж, Богд хааны өвлийн ордныг музей болгон өөрчилсөн Унгарын иргэн Гелета Йозеф Монгол улсад амьдарч, шинэ Монголын яаманд мэргэжилтнээр ажиллаж байв.

Дэлхийн I дайны дараа Монголд ирсэн Унгаруудын тухай Надь Кароль гэдэг Унгар хүний 1985 онд хэвлүүлсэн “Есдүгээр дахин төрөлт” номон дахь аян замын тэмдэглэлүүдээс уншиж болно. Богд хаант Монгол Улсаас хойш Хүн эмнэлгийн анхны тусламжийг (1911-1921) хүн амд болон цэргүүдэд үзүүлсэн хүн бол Радноти Андор юм. Тэрээр 1914 онд цэргийн албанд татагдан очоод дайны үеэр оросуудад олзлогдож, улмаар 1915 онд суллагдан Оросын цэргийн эмнэлэг ба Дээд Үдийн Улаан загалмайн нийгэмлэгийн больницод их эмчээр ажиллаж байжээ. Дараа нь хэсэг унгар нөхдийн хамт улаан цэргийн отряд байгуулан дарга, их эмчээр мөн Сэлэнгэ аймагт их эмчээр дараа нь Хиагтын эмнэлгийн даргаар

ажиллажээ. Радноти Андор 1922 оны эхээр Ардын цэргийн хүн эмнэлгийн хэлтсийн сургагч, хүн малын өвчнийг эмчлэх хэлтсийн дарга зэрэг албыг хашиж байгаад 1930 оны эхээр Унгар луу буцсан.

Барилгын өрлөгч мэргэжилтэй Баадер Паал Улаанбаатар хотод эмнэлэг, их сургууль, дунд сургууль болон бусад шинэ барилга байгууламжуудыг барихад гар бие оролцжээ. Тэрбээр 1958 онд Унгар луу буцсан. 1955 онд түүний хүү Баадер Енө эмч Нэгдүгээр эмнэлэгт мэс заслын тасгийн эмчээр ажиллаж байгаад Монгол улсын гавьяат эмчийн шагналыг хүртсэн. Өндөр насныхаа тэтгэвэрт гарснаас хойш Унгарын Элчин сайдын яаманд жижүүрийн ажил хийж байв.

Дараагийн унгар хүн бол Мээсаарош Яанош. Тэрээр 1916 онд Оросуудад олзлогдон улаан цэргүүдтэй нийлэн Монголд ирээд Монгол дахь улаан цэргийн армийг бэхжүүлэхэд тусалсан.

Дэлхийн I дайны үед Оросуудад олзлогдон Сибирыг байж байгаад дараа нь Монгол руу ирсэн өөр нэгэн унгар хүн бол монголчууд “Германы Шаллай” хэмээн нэрлэдэг Шаллай Енө байв. Тэрээр 1950-иад он хүртэл Сэлэнгийн Алтанбулагт амьдарч байсан, уран дархан, маш үнэнч шударга нэгэн байв.

Дэлхийн хоёр дайны хооронд (1920-1944) Унгарууд Монголын түүх соёлын талаар ихэд сонирхож байсан бөгөөд нэн ялангуяа Хүннүчүүдийн угсаа гарвал нь Унгар судлаач, аялагчдын сонирхлыг ихэд татаж байжээ. Тэр үед судлаач Баратоши Балог Бенедек Ази руу аялж, Хүннү болон Монголчуудын тухай ном бичсэн бол судлаач Лигети Лоюш Өвөр Монголын сүм хийдүүдийн талаар судалгаа хийжээ. Гелета Йозеф хэд хэдэн судалгаа бичиж, Унгаруудад



Монголын талаар лекц уншжээ.

1950 онд хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосны дараа дээд түвшний айлчлалууд эхэлж, хамтын ажиллагааны хэд хэдэн чиглэлийг тодорхойлов. 1957 он бол хоёр орны Дипломат харилцааны хувьд чухал үе байсан. Энэ үед соёл, шинжлэх ухааны хамтын ажиллагааны хэлэлцээр байгуулагдсан бөгөөд энэ хүрээнд олон зуун монгол оюутан Унгар улсад суралцах боломжтой болсон юм. Мөн энэ онд геологи, гидрологи, анагаах ухаан, дорно дахин, археологи, амьтан судлалын салбарт өргөн цар хүрээг хамарсан экспедиц ажиллуулах хамтын ажиллагааны боломжууд нээгдсэн юм. Энэхүү хамтын ажиллагааны хүрээнд Унгарын геологичид Монголд 420 худаг гаргаж, 1,3 сая га газрыг усаар хангах боломжтой болгосон байна.

Манай хоёр орны хувьд хамтын ажиллагаанаас гадна Эдийн засгийн харилцан туслалцах зөвлөл /ЭЗХТЗ/-ийн хүрээнд хөтөлбөрүүд хэрэгжиж, Унгар улс нь Монгол улсад хандивлагч орон болжээ. 1962 онд Монгол Улс Эдийн засгийн харилцан туслалцах зөвлөлийн гишүүн болсон бөгөөд энэ үеэр манай хоёр орны хамтын ажиллагаа илүү өргөн хүрээнд явагдсан гэж болно. 1965 оны 9 дүгээр сард Кадар Яанош тэргүүтэй Унгарын нам, Засгийн газрын төлөөлөгчид Монгол Улсад албан ёсны айлчлал хийж, социалист орнуудын найрамдал, хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурав. Энэ хүрээнд Унгарын талаас Улаанбаатар хотод хувцасны үйлдвэр, 1973 онд Сонгино дахь Биокомбинат, 1974 онд Дарханы махны үйлдвэрийг барьж байгуулан Монгол улсын Засгийн газарт хүлээлгэн өгчээ. 1984 онд Цагаан Давааны орд газраас олдсон

вольфрамын нөөцийг ашиглах гэрээг үзэглэсэн байна. Унгарын хамтын ажиллагааны хүрээнд Хархорин хотод гурилын үйлдвэр, Архангай, Баянхонгор аймгуудад бетоны үйлдвэрүүд баригдсан ба тэдгээрийн зарим нь өнөөдрийг хүртэл Монгол улсын аж үйлдвэрийн чухал бааз хэвээр байж үйл ажиллагаагаа явуулж байна. 1970-аад оны сүүлчээр Монголд 2000 орчим унгар хүн ажиллаж байсны тэн хагас нь Улаанбаатарт ажиллаж байсан.

Үүний дараа хоёр улсын хооронд Төр, засгийн дээд түвшний болон эрдэм шинжилгээний айлчлалууд олон удаа болж байсан. 1970 онд Унгарын Ерөнхийлөгчийн Зөвлөлийн дарга Лошонци Паал Монгол Улсад, 1972 онд Сайд нарын Зөвлөлийн Ерөнхийлөгч Фок Енө Улаанбаатарт айлчилсан бол 1974 оны 5 дугаар сард Юмжаагийн Цэдэнбал тэргүүтэй Монголын нам, засгийн газрын төлөөлөгчид Унгарын Будапешт хотноо зочлон очсон юм. Ингээд хоёр улс Будапештэд консулын гэрээ байгуулж, 1975 оны 1-р тогтоолоор батлав.

1984 онд Монгол Ардын Хувьсгалт Намын Төв хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга Жамбын Батмөнхтэй найрамдал, хамтын ажиллагааны шинэ гэрээ байгуулав.

1987 оны 6 дугаар сард БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн дарга Жамбын Батмөнх Унгарт айлчлах үеэр хоёр орны эдийн засаг, техник, шинжлэх ухааны хамтын ажиллагааны урт хугацааны хөтөлбөрт гарын үсэг зуржээ.

XX зууны дунд үеэс хоёр орны хамтын ажиллагааны хүрээнд Унгарын олон эрдэмтэн, мэргэжилтнүүд Монголд судалгаа хийхээр ирж, Монголын их дээд сургуулийн багш, оюутнууд

Унгарын их дээд сургуульд мэргэжил дээшлүүлж, суралцах боломжтой болжээ. 1960 онд Унгарын археологич Габори Миклош Монголд ирсний дараа 1961 онд Унгар-Монголын археологийн экспедиц байгуулагдсан бөгөөд тэрхүү экспедиц 1990 он хүртэл Эрдэли Иштваны удирдлаган дор ажиллаж, эртний морьгон нүүдэлчдийн олон чухал олдворуудыг олж илрүүлжээ.

Унгарын алдартай зохиолчдын нэг болох Молнар Габор 1960-аад оноос хойш Монголын Зохиолчдын эвлэлийн хорооны урилгаар Монголд гурван удаа айлчилсны дараа ард түмний аж амьдрал болон соёл иргэншлийн тухайд хоёр ч номыг мажар хэлээр хэвлүүлжээ.

Угсаатны зүйч Вильмош Диосэги мөн 1960 онд Монголд судалгааны ажлаар ирснээр Унгарын угсаатны зүйг олон үнэт зүйл, гэрэл зургаар баяжуулж, ардын аман зохиолын цуглуулгатай болгожээ. Бямбын Ринчен 1956 онд Унгарын ШУА-д докторын зэрэг хамгаалсан түүний “Монгол бичгийн хэлний зүй” хэмээх найман дэвтэр судалгааны бүтээл байдаг. Мөн 1956 онд бичсэн “Баруун этгээд зорчсон тэмдэглэл” нь маш алдартай бөгөөд уг тэмдэглэлдээ докторын зэрэг хамгаалахаар Мажар улсыг зорих замдаа үзэж харсан зүйлс, уулзаж танилцсан хүмүүсээ өөрийн бодрол дүгнэлтийн хамт бичиж үлдээсэн байдаг. 1957 онд Бямбын Ринченгийн урилгаар Унгарын судлаач Лигети Лоюш-ийн шавь нар болох Кара Дьёрдь (Хар Дорж), Рона-Таш Андраш, Көөхалми Каталин нар Монгол улсад айлчилсан. Унгарын судлаач Лигети Лоюш ба түүний шавь Кара Дьёрдь нар Унгарын монгол судлалд чухал үүрэг гүйцэтгэсэн бөгөөд монгол хэл

шинжлэл, бурханы шашин, бичиг соёл, уран зохиолын чиглэлээр голчлон судалгаа хийдэг байв.

Лигети Лоюш 1942 онд Өтвөш Лорандын Их сургуулийн Төв Азийн тэнхимийг байгуулжээ. Түүний шавь нараас монгол, хятад, төвд судлалын олон алдартай судлаачид төрсөн бөгөөд монгол судлалаар Кара Дьёрдь, Беше Лоюш, Шаркөзи Алис, Татар Магдолна, Леринц Ласло нарыг нэрлэж болно.

Леринц Ласло нь Монголын домог, ардын аман зохиол, түүхийн судалгаа хийж, 1990-ээд оноос тууж бичиж эхэлсэн бөгөөд дорно дахин тэр дундаа Монголын соёлыг Унгарт хамгийн амжилттай сурталчилсан зохиолчдын нэг байжээ.

Унгарын амьтан судлаач Касаб Золтан 1963-1968 оны хооронд Монголд зургаан удаагийн судалгааны аялал хийжээ. Тэрбээр энэхүү судалгааныхаа ажлаар Унгарын Байгалийн Түүхийн Музейг хагас сая сээр нуруугүй амьтдын цуглуулгаар баяжуулсан бөгөөд үүнд 200,000 төрлийн хорхой багтжээ. Мөн тэрээр Төв Азийн 60 шинэ амьтны 1600 зүйлийн талаар тайлбар гаргасан юм.

1987 оны 5 дугаар сард Унгарын нэрт яруу найрагч Петөфи Шаандорын “Эрх чөлөө, хайр” шүлэг болон бусад 120 шүлгийн түүвэр монгол хэлээр хэвлэгдсэн нь олны талархлыг ихэд хүлээж байв. 1990-ээд оноос хойш яруу найраг, уран зохиолын орчуулагч Шаарошди Даваахүү Ганболд Унгарын зохиолч, яруу найрагчдын бүтээлийг монгол хэлнээ хөрвүүлж эхэлсэн. Түүний орчуулсан бүтээлүүдийг үнэлж, 2009 онд Унгарын яруу найраг, уран зохиолын салбарын шилдэг бүтээлүүдэд олгодог Балашши Балинтын нэрэмжит “Дурсгалын сэлэм”-ээр шагнасан байна.



Унгарууд орчин үеийн монголын яруу найрагч, зохиолчдын бүтээл туурвилуудтай Унгарын эрдэмтэн, судлаач Кара Дьёрдь буюу монголчуудын сайн мэддэгээр Хар Доржийн эмхэтгэсэн бүтээлүүдээс голчлон үзэж, танилцдаг. Монголч эрдэмтэн Бирталан Агнешийн удирдлагаар 2015 оноос эхлэн жил бүр Унгарын Лакителекийн Ардын сургуулийн монгол хэлний ангийн оюутнууд Монгол-Унгарын яруу найраг, уран зохиолыг орчуулах уулзалтыг зохион байгуулдаг болсон юм.

Зөвлөлт Холбоот Улс задарсны дараа Унгар-Монголын харилцаа шинэ түвшинд гарч, Эдийн засгийн харилцан туслалцах зөвлөл татан буугдаж, Унгарын Засгийн газрын улс төрийн чиглэл өөрчлөгдсөн байна. Энэ үед Унгарын талаас Монголтой найрамдалт харилцаагаа хэвээр үлдээж, Засаг төрийн дээд хэмжээний айлчлал ойр ойрхон болж, Өтвөш Лорандын нэрэмжит Их сургуулийн Төв Азийн тэнхим болон Сегедийн их сургуулийн Алтай судлалын тэнхимд боловсрол, шинжлэх ухааны хамтын ажиллагаа үргэлжилж байсан ч хоёр орны эдийн засгийн харилцаа суларсан байсан. Гэвч энэ үед Өтвөш Лорандын нэрэмжит Их сургуулийн Төв Азийн тэнхим, монгол судлаач Агнеш Бирталан, Алис Шаркози, Геза Бетленфалви нар болон Монголын Шинжлэх ухааны академийн Хэл судлалын хүрээлэнгийн хамтын ажиллагааны үр дүнд Унгар-Монгол хэл аялгуу, ардын уран зохиолын нэлээд хэдэн ном зохиол хэвлэгдэн гарсан юм.

Винкович Юдит нь Ференц Хоппын Азийн Урлагийн Музей дэх Монголын Буддын шашны дурсгалт зүйлийн талаар судалгаа хийсэн бол харин Алис

Шаркози нь Өтвөш Лорандын нэрэмжит Их сургуулийн Төв Азийн тэнхимийн багт багтан Монголын Буддизмын чиглэлээр гарамгай судалгаа хийжээ.

Унгарын Шинжлэх Ухааны Академийн Номын сан, Мэдээллийн төвийн Дорно дахины фондод Монголоос гаралтай монгол, төвд гар бичмэл, модон гар бичмэл материалууд хадгалагддаг бол харин Угсаатны зүйн музейд Вильмош Диосегийн хийсэн судалгааны эх сурвалж болох 19-р зууны сүүлч, 20-р зууны эхэн үеийн Буддын шашны дурсгалт зүйлс байдаг.

2020 онд Олон улсын Монгол Судлалын Холбооноос тус холбооны Ерөнхийлөгч Бирталан Агнешийн удирдлага дор Унгарын ШУА-ын Номын сан, Унгарын Үндэсний музей, Ференц Хоппийн Азийн урлагийн музей, Унгарын Угсаатны зүйн музейн сан хөмрөгт хадгалагдаж буй эдгээр гайхамшигт өв соёлын цуглуулгаас дээжлэн багтаасан “Унгар дахь монголын өв соёлын дурсгалууд” номыг англи, монгол хэл дээр гаргасан байна.

1990-ээд оны үед хоёр улс цаашдаа зах зээлийн эдийн засагт тохирсон хамтын ажиллагааг хийх нөхцөлийг бүрдүүлсэн. 1994 онд Ерөнхийлөгч Гөнц Арпад Монголд, дараа жил нь Ерөнхий сайд Пунсалмаагийн Очирбат Будапештэд айлчилжээ. Мөн энэ онд Хөрөнгө оруулалтыг хамгаалах, давхар татвараас зайлсхийх тухай хэлэлцээрт гарын үсэг зурсан бол 1995 онд Монгол улс өмнөх хамтын ажиллагааны хүрээнд хийгдсэн ажлуудын төлбөрийг Унгар улсад төлж эхэлсэн байна. Монгол улсын Ерөнхий сайд М.Энхсайханы 1998 оны 1 дүгээр сард Унгар улсад хийсэн айлчлалын үеэр найрамдалт, хамтын ажиллагааны тухай гэрээ

байгуулсан нь 1984 оны гэрээг шинэ шатанд гаргасан явдал байв. 2005 онд Монгол Улсын Ерөнхийлөгч Нацагын Багабанди Бүгд Найрамдах Унгар Улсын Ерөнхийлөгч Маадл Ференц-д бараалхав. Өндөр түвшний айлчлалууд хийгддэг байсан хэдий ч хоёр улсын эдийн засгийн харилцаа санасны дагуу хөгжөөгүй бөгөөд 2006 онд Унгарын Засгийн газрын хуралдаанаар Улаанбаатар дахь Элчин сайдын яамаа хаах шийдвэр гаргасан. Улмаар Бээжин дэх Унгарын Элчин сайдын яаманд Монгол Улсыг магадлан итгэмжлүүлж, Чулууны Гантулгыг Улаанбаатар дахь Өргөмжит консулаар томилсон бөгөөд тэрээр 2012 оноос хойш хоёр орны харилцааг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

Түүнчлэн Өтвөш Лорандын нэрэмжит Их сургуулийн монголч эрдэмтэн Бирталан Агнеш 2015 онд Монгол Улсаас Унгарт суугаа Соёлын элчээр, 2016 онд Олон улсын Монгол судлалын холбооны ерөнхийлөгчөөр сонгогдон хоёр орны харилцааг хөгжүүлэхэд маш чухал үүрэг гүйцэтгэж байна.

2000-аад онд Унгар, Монголд хоёр орны гэрэл зураг болон уран зургийн үзэсгэлэнгүүд зохион байгуулагдаж оркестрын концертууд тоглогдож байсан нь хоёр улсын соёлын хамтын ажиллагааг сэргээхэд чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

2010 онд Унгар-Монголын хооронд Дипломат харилцаа тогтоосны 60 жилийн ойн хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайд Сүхбаатарын Батболд Унгарт айлчилсан бөгөөд мөн онд Унгарын Засгийн газар Дорно дахин руу чиглэсэн бодлогоо зарлаж, үүнд Монгол Улсын гүйцэтгэх үүргийг дахин онцлов. 2013 оны 10 дугаар сард

Унгарын Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын Монгол дахь салбар байгуулагдсан нь хоёр улсын эдийн засгийн харилцаа сэргэж эхэлсний илрэл юм.

Унгарын Элчин сайдын яам Улаанбаатарт нээгдэхээс өмнө буюу 2014 оны 10 дугаар сард Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдорж Унгарт айлчлах үеэр Өтвөш Лорандийн нэрэмжит Их сургуульд Монгол судлалын төв нээгдэв.

Энэ үед Олон улсын Парламентын Холбооны Унгар, Монгол дахь салбарууд хоёр орны парламентад үйл ажиллагаа явуулдаг болов. Унгарын парламентын гишүүн Хорват Ласло 2014 оноос хойш Унгар-Монголын Парламентын бүлгийн даргаар ажиллаж байгаа бол Монгол-Унгарын Парламентын бүлгийн даргаар Унгарын Мишколц хотын Их сургуулийн Хууль зүйн Факультетэд докторын зэрэг хамгаалсан Жалбасүрэнгийн Батзандан 2012–2020 онд, УИХ-ын гишүүн Наянтайн Ганибал 2020 оны 8-р сараас эхлэн ажиллаж байна.

Унгар Улсын Засгийн газрын шийдвэрээр 2015 онд Монгол улсад Элчин сайдын яамаа дахин нээсэн. Энэ хугацаанд боловсролын салбарын харилцаа, хамтын ажиллагаа илүү өргөн хүрээнд хөгжиж байна. Тухайлбал, Унгарын засгийн газрын Stipendium Hungaricum тэтгэлэгт хөтөлбөрт нэг жилд хамрагдах оюутны тоо өмнө 100 байсан бол 2016 онд энэ тоог 200 болгож нэмэгдүүлсэн юм.

Цаашид хоёр орны хот, аймгуудын ахан дүүсийн харилцаа, хамтын ажиллагааг сэргээн хөгжүүлэх нь бидний ойрын зорилт болж байна. Унгарын Капошвар хот Дархан хоттой, Секешфехервар хот Эрдэнэт хоттой тус



тус ах дүүгийн харилцаатай ажиллаж байна. Мөн Унгарын Бач-Кишкун аймгийн Санк тосгон Төв аймгийн Архуст сумтай, Кашкантю тосгон Булган аймгийн Сайхан сумтай, Акасто тосгон Булган аймгийн Хутаг-Өндөр сумтай ах дүүгийн харилцаа тогтоожээ. Төв аймгийн Эрдэнэ суманд байрлах Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв нь “Mezőtúr Mongol Agrár Zrt” компанитай холбоо тогтоосон байна.

2015 онд Унгарын Ерөнхийлөгч Адер Яанош мөн Гадаад хэрэг, худалдааны сайд Сияарто Петер нар албан ёсны айлчлал хийжээ. Энэ үеэр Улаанбаатар хотод Элчин сайдын яамаа нээсэн бөгөөд нээлтийн үйл ажиллагаанд Гадаад хэрэг, худалдааны сайд Сияарто Петер оролцжээ. 2016 онд Унгарын Ерөнхий сайд Орбан Виктор Монголд айлчилж, Ерөнхий сайд Чимэдийн Сайханбилэг, УИХ-ын дарга Зандаахүүгийн Энхболд, Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдорж нартай хэлэлцээ хийв. 2017 онд Будапешт хотноо зохион байгуулагдсан Жүдо бөхийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд Монгол Улсын Ерөнхийлөгч Халтмаагийн Баттулга зочлон очсон. 2019 оны 6 дугаар сард Унгарын Гадаад хэрэг, худалдааны сайд Сияарто Петер сайд Монгол Улсад дахин албан ёсны айлчлал хийв.

Дэлхий нийтийг хамарсан цар тахлын энэ үед ч хоёр орны харилцаа, хамтын ажиллагаа зогсолтгүй үргэлжилж, Төр, засгийн тэргүүнүүдийн дээд хэмжээний уулзалтуудыг цахимаар зохион байгуулж байна. 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр Унгар, Монголын Засгийн газар хооронд байгуулсан Санхүүгийн хэлэлцээрийн хүрээнд Сонгино дахь Биокомбинатын

өргөтгөлийн төслийн зээлийн гэрээнд гарын үсэг зурснаар 2020 оны 5 дугаар сарын 21-нд Биокомбинатын вакцины үйлдвэрийн шавыг тавив. 2020 оны 9 дүгээр сарын 29-нд Унгар Улсын Гадаад хэрэг, худалдааны сайд Сияарто Петер, Монгол Улсын Гадаад харилцааны сайд Н.Энхтайван нар цахим уулзалт хийв. 2020 оны 11 дүгээр сарын 6-ны өдөр Унгарын Ерөнхий сайд Орбан Виктор, Монгол Улсын Ерөнхийлөгч Халтмаагийн Баттулга нар дээд хэмжээний цахим уулзалт хийж, хоёр орны харилцаа, хамтын ажиллагааны цаашдын чиглэлийг илүү өргөн хүрээнд ярилцав.

2016 оноос хойш Унгар, Монголын Шинжлэх Ухааны Академийн Биологийн хүрээлэнгийн хоорондох хамтын ажиллагааны хүрээнд чуулга уулзалтуудыг тогтмол зохион байгуулж байна. 2020 оны 7 дугаар сард Монгол Улсын ШУА-ийн Олон улсын хүрээлэн болон Унгар Улсын Гадаад эдийн засаг, гадаад харилцааны хүрээлэнгүүд цахим хурал хийж, хамтын ажиллагаагаа эхлүүллээ. Өдгөө хоёр байгууллага нь Элчин сайдын яамны дэмжлэгтэйгээр хоёр орны Дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ойд зориулсан товхимол номыг гаргахаар ажиллаж байна.

Сүүлийн арван жилийн хугацаанд хоёр орны биеийн тамир, спортын салбарын хамтын ажиллагаа ч өргөжин тэлж байгаа нь сайшаалтай юм. 2014 оноос хойш Монголын хөлбөмбөгчид Пушкашийн Хөл бөмбөгийн хүрээлэнд суралцах боломжтой боллоо. Мөн Монголын сур болон морьт харвааны “Хаан Монгол” холбоо болон Унгарын “Немети морьт харваачдын холбоо”-ны хооронд хамтын ажиллагааны өргөн боломж

нээгдснээр 2019 онд Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан морьт харвааны тэмцээнд Унгарын тамирчид ирж оролцов. Манай хоёр ард түмний хувьд жүдо, бокс, бөхийн барилдаан гэх зэрэг спортын төрлүүд бас нягт уялдаатай хөгжиж байна. Монголын тамирчид Будапешт хотноо зохион байгуулагддаг Олон улсын болон дэлхийн хэмжээний тэмцээн уралдаанд тогтмол оролцдог болов. 2020 оны 9 дүгээр сард Унгарын спортын шинэ төрөл болох Текболл /Teqball/ Монгол оронд хөгжих үндэс сууриа тавив. Мөн хамтын ажиллагааны хүрээнд 2020 оны зун Монголын циркчид Унгарт аялан тоглолт хийжээ.

Улаанбаатар дахь Унгарын Элчин сайдын яам дахин нээгдснээс хойш Унгарын түүх, соёл, шинжлэх ухааны дурсгалуудыг танилцуулах олон арга хэмжээг зохион байгуулж байна. Тухайлбал, 2017 онд Кодаль Золтан (1882-1967) нэрт хөгжмийн зохиогчийн үйл ажиллагааны талаар үзэсгэлэн нээгээд 2018 онд Унгарын нэрт архитектор Маковец Имре /1935-2011/-гийн уран бүтээлийн үзэсгэлэн мөн 2019 оны 11 дүгээр сард Унгарын “Дундад зууны үеийн зурагт шастир”-аас сэдэвлэсэн “Аттилагийн өв залгамжлагчид” гэрэл зургийн үзэсгэлэнг зохион байгууллаа.

2020 онд хоёр улсын Кино урлагийн салбарын хамтын ажиллагааны үүд нээгдэж, Монголын үндэсний кино хороо ба Унгарын үндэсний кино урлагийн хүрээлэнгийн хамтын ажиллагааны эхлэл тавигдлаа. Энэ хүрээнд Унгарын хөрөнгө оруулалт, дэмжлэгтэйгээр Монголд дэлхийн жишигт нийцсэн кино үйлдвэр

байгуулах, хоёр улсын түүх, өв уламжлалын чиглэлээр хамтарсан уран бүтээл хийх зэрэг маш олон ажлууд төлөвлөгдөөд байна. Киноны салбарын хувьд өмнө нь “Унгарын кино өдрүүд”-ийг Монголд зохион байгуулж, “Капитан Тенкеш” олон ангит кино болон бусад хэд хэдэн киног Монголын үзэгчдэд хүргэсэн байна. Унгарын антропологич, монгол судлаач Фүрэди Золтангийн бүтээсэн монголчуудын тухай баримтат кинонууд нь хоёр орны соёлын харилцааг бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэснийг энд дурдах хэрэгтэй.

Мөн энэ онд “Бяцхан зөгий” хэвлэлийн газраас Унгарын нэрт зохиолч Молнар Фэрэнцийн “Паулын гудамжны хөвгүүд” романыг монгол хэлээр орчуулан хэвлүүлсэн нь хоёр орны утна зохиолын салбарын хөгжилд оруулж буй томоохон хувь нэмэр юм.

Хоёр орны найрсаг харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэхэд Элчин сайд, консулууудаас гадна Унгарт төгссөн монголчуудын холбоо чухал гүүр болж, Элчин сайдын яамнаас зохион байгуулсан арга хэмжээнүүдэд идэвхтэй оролцохоос гадна өөрсдийн санаачлагаар олон ажлуудыг зохион байгуулдаг юм. Мөн Унгарт амьдардаг монголчууд, тэнд сурч буй оюутнууд болон бусад олон байгууллага, хувь хүмүүс ч маш их дэмжлэг үзүүлдгийг дурдах хэрэгтэй.

Цаашдаа Унгар, Монголын өргөн цар хүрээтэй харилцаа улам бүр өргөжин бэхжиж, хоёр орны ард түмэн бие биетэйгээ улам дотносож, бие биенийхээ түүх, соёл, үнэт зүйлтэй танилцана гэдэгт итгэж байна.



MAGYAR-MONGOL DIPLOMÁCIAI KAPCSOLATOK: A TÖRTÉNELMI OLDALÁN

Magyarország és Mongólia 1950. április 28-án létesített diplomáciai kapcsolatot, majd Budapesten és Ulánbátorban 1957-ben diplomáciai képviselőt nyílt. Bár a hivatalos, államközi kapcsolatok viszonylag későn létesültek, a két ország népe évszázadok óta kapcsolatban áll egymással.

Julianus, magyar Domonkos-rendi szerzetes volt az, aki Európában elsőként írt a kontinens keleti peremén megjelent mongolokról. Második útja során, 1237-ben levelet hozott IV. Béla magyar királynak Batu kántól. Mivel a mongolok 1241-1242-es hadjárata után a Magyar Királyság szomszédos lett a mongolok által alapított Arany Horda birodalommal, kereskedelmi és diplomáciai kapcsolatokat építettek ki. Abban az időben magyar utazók, tudósok és keresztény misszionáriusok megfordultak, sőt sokan az Arany Horda területén is éltek.

A 18. században magyar kutatók és utazók őseik egykori lakóhelyeit akarták megtalálni, ezért több kutató utat vezettek kelet felé, és jó néhány könyvet is írtak eredményeikről. A magyarok keletkutatási céljairól egy főnemesi

levél tesz tanúbizonyságot. 1878-ban Széchenyi Béla a következő levelet küldte a kínai kormányzónak Belső-Mongólia és az ősi Selyemút felé irányuló kutatásának céljáról, mely bizonyítja, hogy a magyarok és a keleti népek történelmi kapcsolatban álltak egymással:

“Nekem nincsenek sem politikai, sem térítői, sem kereskedői, hanem tisztán tudományos, történelmi és kegyeleti céljaim. A mit leginkább óhajtok az: beutazni ama területet, ahonnan mi magyarok véleményünk szerint származunk, látni azon országokat, ahol egykor őseink laktak, tisztelem és becsülésem adóját leróni sírjaikon és imádkozni azokon új hazánk, Magyarország javáért és fennállásáért, melyet a kilencedik században Európa szívében alapítottunk.”

Miközben a magyarok őseik után kutattak, sokat tanultak a francia Joseph de Guignes: A hunok, mongolok, türkök és tatárok története című, 1757–1765 közötti művéből, melyben a szerző a Közép-Ázsiában és Mongóliában élt hunok történelmét foglalta össze. A 19. század első felében Kőrösi Csoma Sándor magyar orientalista azt tervezte, hogy a

Sárga-folyó vidékén élt hunok utódait felkeresi Belső-Mongóliában, a Sárga-folyó medencéjében, ám sajnos nem jutott el odáig. Később a Magyar Tudományos Akadémia rendes tagja, Fogarasi János állította össze a Magyar nyelv szótárát, amelyben összehasonlította a magyar szavakat a mongollal, és arra a következtetésre jutott, hogy a hasonló szavak a hun nyelv maradványai. Fogarasi János eszmecserét folytatott Vámbéry Ármin turkológussal arról, hogy a nyelvi kapcsolatok részletes kutatására egy ifjú kutatót kellene találni. Vámbéry Szentkatolnai Bálint Gábor fiatal, tehetséges nyelvészt ajánlotta.

A Magyar Tudományos Akadémia Szentkatolnai Bálint Gábort a Kaszpi-tenger partján lévő Kalmükiába küldte, amelyet nyugati mongolok laktak. Bálint hamar megtanulta e nyugat-mongol nyelvjárást, valamint a tatár, a cseremis és orosz nyelveket. 1872-ben kérvényt írt a Magyar Tudományos Akadémiának, hogy a kelet-mongol nyelvjárások tanulmányozása végett a mongol fővárosba, Örgöö-be (Urga) utazhasson. Az engedély megérkezése után elutazott Szentpétervárra, hogy az orosz cár támogatását kérje útjához. A cári udvarban Zichy Mihály, a cár festője segített Bálintnak és hamarosan megkapta az orosz cár parancsát, aki fedezte a magyar kutató költségeit is. Bálint 1873 februárjában hagyta el Oroszországot, és két hónap múlva ért Örgöö-be. A cár utasítására az Orosz Konzulátuson lakott. 155 napot töltött Mongóliában, mely idő alatt több tucatnyi folklór szöveget gyűjtött. 1875-ben két magyar nemes, Zichy József és Zichy Ágost Pekingből indult Mongólia felé. Átkeltek a Góbi-sivatagon majd Oroszország felé haladtak tovább. A Jegyzetek a Góbiról című úti

beszámolójuk megírásához Bálint Gábor feljegyzéseit is felhasználták.

Eközben Budapesten 1872-ben megalakult az Altajisztikai Tanszék a Budapesti Tudományegyetemen, és ugyanabban az évben hasonló intézmény alakult Kolozsvárott, az akkori Ferencz József Tudományegyetemen is.

Zichy Jenő tudós és utazó 1898-ban szintén a mongol fővárosba, Örgöö-be látogatott. Egyhetes tartózkodása során kutatásokat végzett, fényképeket készített. Magyar néprajzkutatók, régészek és zoológusok kísérték, akik szintén értékes anyagokat gyűjtöttek. Zichy Jenő 1898. szeptember 11-ig tartózkodott Örgöö-ben, majd Pekingbe utazott. Zichy és csapata rengeteg érdekes anyagot gyűjtött Mongóliáról és fővárosáról, Örgöö-ről, melyeket eddig kevésbé használtak fel a mongolisztikai kutatásokban.

Mivel a magyarok és a mongolok is a hunokat tekintik ősüknek, ezt a kétoldalú kapcsolatok egyik meghatározó része lehet. A mongol régészek közül Diimaajav Erdenebaatar régész végzett összehasonlító kutatást az ázsiai és az európai hunokról 2012 és 2016 között. Három tanulmányutat tett Magyarországon és Románia magyarlakta területein; régészeti és néprajzi feltárásairól magyar és mongol tudományos folyóiratokban számolt be. Obrusánszky Borbála történész, mongolista hunokról szóló monográfiája mind Mongóliában, mind Magyarországon megjelent.

Az első világháború végén az orosz csapatok fogságába esett, a szibériai hadifogoly táborokból szabadult magyarok egy része nyugat felé indult Magyarországra, néhányan viszont kelet felé igyekeztek hazajutni. Nagy Imre, Magyarország későbbi miniszterelnöke



együtt élt a szelenge burjátokkal, Rákosi Mátyás későbbi kommunista pártfőtitkár pedig a csitai burjátok között élt három éven át. Geleta József mérnök évekig maradt a mai Mongólia területén, és a mongol Pénzügyminisztériumban szakértője lett. Ő tervezte Mongólia első parlamentjét (későbbi Bömbögör Nagoon színház), az első fűtőközpontot, és segítette a Bogdo Gegen palotáját múzeummá alakítani.

Az első világháború után Mongóliába került magyarokról Nagy Károly: A kilencedik újjászületés című, 1985-ben megjelent, három utazásának élményeit összegző könyvében olvashatunk. Radnóti Andor volt az első orvos, aki ellátta a mongol lakosságot és a hadsereget Bogdo Gegen uralmát (1911-1921) követően. Radnóti 1914-ben vonult be a hadseregbe; a háború alatt az oroszok foglyul ejtették, majd 1915-ben szabadon engedték. Orvosként dolgozott a Felső-Udéli (ma: Ulan-Ude) Vöröskereszt kórházban, majd magyar társaival megalakította a Vörös Hadsereg különítményét. Vezetőként és orvosként dolgozott, előbb a Szelenge vidékén orvosként, később pedig a Hjaktai Kórház vezetőjeként. Radnóti Andor 1922. elejéig a Mongol Forradalmi Párt Egészségügyi Tagozatának elnöke volt. Később oktatóként tevékenykedett a Népi Katonai Orvosi Osztályon, valamint az Emberi és Állati Betegségek Osztályának vezetője lett. Családjával az 1930-as évek elején tért vissza Magyarországra. Báder Pál kőműves szintén hadifogoly volt: előbb Szibériában, majd 1924-től Mongóliában élt, és Ulánbátorban egyetemek, kórházak, középiskolák és egyéb új épületek építésében vett részt. Családjával Ulánbátorban élt; 1958-ban tért haza Magyarországra. Fia, Báder Jenő orvos lett, a Mongol Népi Kórházban dolgozott:

1955-ben ő vezette a Sebészeti Osztályt. Elnyerte a Mongólia érdemes orvosa címet. Nyugdíjba vonulását követően szolgálatot teljesített az ulánbátori Magyar Nagykövetségen. Mészáros János 1916-ban esett orosz hadifogságba. Csatlakozott a bolsevikokhoz, és a harcok révén eljutott Mongóliába, ahol szerepet játszott a modern lovas hadsereg megszervezésében. Szintén az első világháború után került Mongóliába Sallai Jenő, akit a mongolok pontosságáról „német Sallai” néven ismertek: az 1950-es évekig Altanbulagban lakott, kézműves volt, és igen becsületes ember hírében állt.

A két világháború közötti korszakban (1920-1944) a magyarokat rendkívül érdekelte a mongol történelem és kultúra, ezen belül is a hunok eredete. Abban az időben Baráthosi Balogh Benedek Ázsiába utazott, és könyvet írt a hunokról és a mongolokról, míg Ligeti Lajos kutató Belső-Mongólia kolostorait és szent iratait tanulmányozta. Geleta József több tanulmányt írt és előadást tartott mongóliai élményeiről a magyar érdeklődőknek.

A két ország diplomáciai kapcsolatainak 1950. évi felvétele után megindultak a magas szintű látogatások, és számos együttműködési területet határoztak meg. 1957 fontos esztendő volt a kétoldalú kapcsolatok szempontjából. Ekkor írták alá a kulturális és tudományos együttműködésről szóló megállapodást, ami lehetővé tette, hogy mongol diákok százai tanuljanak Magyarországon. Ugyanebben az évben nagyszabású expedíciók indultak a geológia, a hidrológia, az orvostudomány, a keleti tanulmányok, a régészet és az állattan területén. Ezen együttműködés keretében a magyar geológusok 420 kutat fúrtak Mongóliában, és 1,3 millió hektár földet láttak el vízzel.

A két ország közötti együttműködés mellett a Kölcsönös Gazdasági Segítség Tanácsának (KGST) keretein belül több együttműködés valósult meg, Magyarország pedig Mongólia adományozójává vált. Mongólia 1962-ben lett a KGST tagja, melynek következtében a kétoldalú együttműködés kibővült. 1965 szeptemberében a magyar párt és kormány képviselői Kádár János vezetésével hivatalos látogatást tettek Mongóliában, és aláírták a szocialista országok közötti barátságról és együttműködésről szóló egyezményt. Ennek keretében Ulánbátorban az 1960-as években ruhagyárat, 1973-ban a Szonginói biokombinátot, 1974-ben Darkhanban pedig húskombinátot hoztak létre, amelyhez a területet a mongol fél biztosította. 1984-ben megállapodást írtak alá a Tsagaan Davaa lelőhelyen talált volfrámtartalék felhasználásáról. A magyar együttműködés keretében malmot építettek Kharkhorinban, betongyárat Arkhangai és Bayankhongor megyében, melyek Mongólia fontos ipari bázisaivá váltak. Becslések szerint az 1970-es évek végén körülbelül 2000 magyar dolgozott Mongóliában, fele közülük Ulánbátorban.

Számos magas szintű kormányzati és akadémiai látogatás valósult meg a két ország között. 1970-ben a Magyar Népköztársaság Elnöki Tanácsának elnöke, Losonczy Pál, majd 1972-ben Fock Jenő, a Minisztertanács elnöke látogatott Mongóliába, 1974 májusában pedig Yumjaa Tsendenbal vezetésével mongol párt- és kormánydelegáció érkezett Budapestre. 1974-ben a két ország konzuli egyezményt írt alá Budapesten, amelyet az 1975. évi 1. számú törvényerejű rendelettel hirdettek ki.

1984-ben új barátsági és együttműködési megállapodást került

aláírásra Jamba Batmunkh-vel, a Mongol Népi Forradalmi Párt Központi Bizottságának főtítkárával. Jamba Batmunkh 1987. júniusi magyarországi látogatása során a két ország hosszú távú gazdasági, műszaki és tudományos együttműködési programot írt alá.

A 20. század közepe óta sok magyar tudós és szakember járt Mongóliában, hogy a kétoldalú együttműködés keretein belül kutatásokat folytasson, a mongol egyetemek oktatói és hallgatói pedig magyar egyetemeken taníthattak, tanulhattak. Gábori Miklós régész 1957-ben látogatott el Mongóliába, ahol az őskor leleteit tanulmányozta. 1961-ben indult a Magyar-Mongol Régészeti Expedíció, amelyet Erdélyi István vezetett 1990-ig: számos fontos leletet tártak fel, köztük lovas nomádok ősi síremlékeit.

Molnár Gábor, a korszak egyik legnevesebb írója az 1960-as évek óta háromszor járt Mongóliában a Mongol Írószövetség meghívására, két magyar nyelvű könyvet írt a mongol életmódról és kultúráról.

Diószegi Vilmos néprajzkutató 1960-ban jutott el Mongóliába, és számos értékes fényképpel, valamint folklórgyűjteménnyel gazdagította a magyar néprajztudományt. Byamba Rinchen, Mongólia kiváló professzora és költője 1956-ban a Magyar Tudományos Akadémián védte meg doktori disszertációját, s megírta naplóját Nyugati utazás címmel, melyben összegezte, mi mindent látott Magyarországon. Byamba Rinchen meghívására Ligeti Lajos tanítványai, Kara György, Róna-Tas András és Kóhalmi Katalin 1957-ben látogattak Mongóliába.

Ligeti Lajos magyar orientalista, valamint tanítványa, Kara György



meghatározó szerepet töltek, töltenek be a magyar mongolisztika fejlődésében: elsősorban összehasonlító nyelvészettel, buddhizmus kutatással, írás- és irodalomtörténettel foglalkoztak. Ligeti Lajos 1942-ben alapította meg az Eötvös Loránd Tudományegyetem Belső-ázsiai Tanszékét. Tanítványai közül számos jeles mongolista, tibetológus és sinológus került ki, köztük Kara György, Bese Lajos, Sárközi Alice, Tatár Magdolna, valamint Lőrincz László, aki a mongol mitológiával, népköltéssel és történelemmel ismertette meg a magyar közönséget, majd az 1990-es évektől regényeket kezdett írni, és azóta is sikeres regényíró Magyarországon: műveiben a keleti kultúrát népszerűsíti, többek között Mongóliát.

1963 és 1968 között Kaszab Zoltán entomológus hat kutatóutat vezetett Mongóliába. Félmillió gerinctelenből, köztük 200.000 ízeltlábúból álló gyűjteményével gazdagította a Magyar Természettudományi Múzeumot. Tanulmányútjai során hatvan új közép-ázsiai állatnemet és 1600 fajt azonosított.

1987 májusában Luvsandamba Khuushaan, híres mongol író szerkesztésében napvilágot látott Mongóliában Petőfi Sándor válogatott verseinek gyűjteménye Szabadság, szerelem címmel, amely mintegy 120 költeményt tartalmazott. A műfordítói munkát az 1990-es évektől Sárosdi Davaakhuu Ganbold folytatta, aki magyar írók és költők műveit ültette át mongol nyelvre. Munkásságát 2009-ben Balassi Bálint-emlékkard adományozásával ismerték el. A kortárs mongol költők, írók műveit elsősorban a Kara György által szerkesztett antológiákból ismerhette meg a magyar közönség, mely hagyományt tanítványa, Birtalan Ágnes folytatta

és bővítette ki 2015-től a Lakitelek Népfőiskolán évente rendezett Mongol-magyar műfordító- és országismereti tábor keretében.

A Szovjetunió összeomlása után a magyar-mongol kapcsolatok új tartalommal működtek tovább. Akkortájt felszámolták a Kölcsönös Gazdasági Segítség Tanácsát, és megváltozott a magyar kormány politikai irányvonala. Magyarország fenntartotta baráti kapcsolatait Mongóliával, továbbra is gyakoriak voltak a magas szintű politikai látogatások, az ELTE Belső-Ázsiai Tanszékén és a Szegedi Tudományegyetem Altajisztikai Tanszékén haladt tovább a kulturális és tudományos együttműködés, ám a gazdasági kapcsolatok meggyengültek. Ezen években zajlott a Magyar-Mongol Nyelvjárás- és Népi Műveltségkutató Expedíció a MTA-ELTE Altajisztikai Kutatócsoport és a Mongol Tudományos Akadémia Nyelvtudományi Intézetének együttműködésében Sárközi Alice, Bethlenfalvy Géza, Birtalan Ágnes és tanítványaik részvételével, melynek eredményeiből számos könyv és tanulmány született. A Hopp Ferenc Ázsiai Művészeti Múzeumban Vinkovics Judit folytatott mongol buddhista kegytárgyakat érintő kutatásokat, a MTA-ELTE Altajisztikai Kutatócsoportban pedig Sárközi Alice végzett kiemelkedő kutatást a mongol buddhizmus területén. A Magyar Tudományos Akadémia Könyvtár és Információs Központjának Keleti Gyűjteménye elsősorban Mongóliából származó mongol és tibeti nyelvű kéziratokat, fanyomatokat őriz, a Néprajzi Múzeumban pedig Diószegi Vilmos kutatásából származó tárgyi emlékeket, valamint 19. század végi, 20. század eleji buddhista kegytárgyakat találhatunk. E gyűjteményekről a Birtalan

Ágnes szerkesztésében, angol és mongol nyelven idén napvilágot látott Mongol emlékek Magyarországon című kötetben olvashatunk.

